



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2025. 04. 25 № 8/2081
танай -ны № -т

Үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралтаар Гүйцэтгэлийн үнэлгээний тайланг хүргүүлэв.

Хавсралт: ... хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА С.ТӨГСДЭЛГЭР

1113270972 5977443

144251516

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

“2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 23 зорилтын хүрээнд 102 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгасан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 87.1%.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүдээс дурдвал: иргэдэд зориулсан эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулах, сүрьеэгийн далд халдвартай тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулах талаар санаачлагатай ажиллажээ.

Гэвч нэг жилийн хугацаанд хэт олон зорилт дэвшүүлсэн, зорилтот түвшин арга хэмжээтэйгээ уялдаагүй, буруу тодорхойлсон, тайланг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиний дагуу бичээгүйгээс үнэлгээ өгөхөд хүндрэл учруулсан, ижил агуулгатай ажлыг хэд хэд ажил болгон салгасан (нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ г.м).

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- Аймгийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн тогтвортой үйл ажиллагааг хангах;
- Ангиографийн тоног төхөөрөмжөөр хангаж, хүний нөөцийг чадавхжуулан, эрүүл мэндийн мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх;
- Сувилахуйн дагнасан төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчид болон эмч, ажилтны сэтгэл ханамжийн судалгааг сар бүр цахимаар авч, үр дүнг тооцон үйл ажиллагаа зохион байгуулах;
Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах арга хэмжээ хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4, 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож, энэ тухай тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчид тухай бүр хүргүүлэх.

3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээний дундаж 83.4%-тай байна.

Гадаад сургалтад нийт албан хаагчдын 20-аас дээш хувийг хамруулахаас 3.0%-ийг хамруулсан, шилжилт хөдөлгөөн нийт албан хаагчдын 15-аас доош хувь байхаар заасан ч 22.0%, албан хаагчдын 34.0%-ийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байгаа нь нь хангалтгүй үзүүлэлттэй байна.

3.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар 61.9 хувь буюу “Хэрэгжих шатанд” байна.

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 33.3%. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл зэрэг 4 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 71.7%;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал (Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга) - 64.6 хувь. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн

судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан зэрэг 4 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 100.0%;

- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 40.0%. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл (авлигын эсрэг, хүний эрх, жендэр болон бусад) зэрэг 3 мэдээллийг ил тод байршуулаагүй;

Байгууллагын албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангахгүй, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, цаг хугацаанд нь хийгээгүй, мэдээллийг дутуу байршуулах эсвэл бүр байршуулахгүй орхих, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулаагүй, зарим шалгуур үзүүлэлтийг оновчгүй тайлагнах, мэдээллийг байршуулаагүй атлаа тухайн шалгуур үзүүлэлтийг 100 хувь хэрэгжсэн гэж тайлагнах, мэдээллүүдийг давхардуулж олон дэд цэсэнд байршуулах зэрэг дутагдлууд байна. Байгууллагын нийгмийн сүлжээний хуудсанд мэдээллийг түлхүү байршуулж, байгууллагын албан ёсны цахим хуудасны тогтмол ажиллагааг хангахгүй орхигдуулж байна.

3.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн **58.3** хувь бөгөөд өмнөх оны түвшнээс сайжраагүй, зорилтот түвшинд хүрээгүй буюу аймгийн дунджаас муу дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

1. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь
 2. В гепатитийн вакцины хамрагдалт
 3. СХТ + Геп В +ХиВ-ийн тавт вакцин
 4. УГУ-ын 3-т вакцин
 5. Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь
 6. 28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь
 7. Үр хөндөлтийн түвшин (15-49 насны 1000 эмэгтэйд)
 8. 1000 жирэмсэнд ногдох үр хөндөлтийн түвшин
 9. Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин
 10. Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин
 11. Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин
 12. Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин
 13. Тархинд цус харвалтын нас баралтын түвшин
 14. Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин
 15. Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин
- Сүрьеэгийн нас баралтын түвшин

16.Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь

17.Вируст гепатитын өвчлөлийн түвшин

3.5 Хэрэглэгчийн үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 86 хувь буюу 4.3 оноо байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу 2024 онд дотооддоо зохион байгуулсан хэрэглэгчийн үнэлгээний тайланг ирүүлээгүй.

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2024 онд эрүүл мэндийн байгууллагын амбулаториор үзүүлсэн болон хэвтэн эмчлүүлж, хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдсан нийт үнэлгээнээс түүвэрлэсэн бөгөөд 2553 хэрэглэгчийн үнэлгээнээс 520 үнэлгээг түүвэрлэж гаргасан.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

4.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад арга хэмжээний үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох, салбарын урт, дунд, богино хугацааны бодлогод нийцүүлэх, ижил агуулгатай ажлыг хэд хэдэн ажил болгож хуваахгүй байх, давхардуулахгүй байхад анхаарах;

4.2 Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр сургалтад тогтмол хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах зэрэг арга хэмжээг авах, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.3 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах;

4.4 Монгол Улсын “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017” стандартыг хангах, стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах;

4.5 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам боловсруулж, мөрдөж ажиллах;

4.6 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулж хэвших, албан ёсны цахим хуудасны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, эрчимжүүлэх;

4.7 Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн зарчмыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн байршуулах;

4.8 Байршуулаагүй байсан буюу 0 үнэлгээ авсан мэдээллүүдийг бүрэн, ил тод цахим хуудсанд байршуулах;

4.9 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.9-д заасан шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг ил тод байршуулах;

4.10 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.11-т заасан худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт хэсэгт Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын тайланг ил тод байршуулах (аудитын тайланд Худалдан авах үйл ажиллагааны гүйцэтгэл байдаг болно);

4.11 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бүлгийн 3.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл хэсэгт тухайн байгууллагаас зарласан тендертэй холбоотой ирж мэдээлэл, зөвлөгөө авсан талаар ил тод байршуулах;

4.12 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн 5.1-д заасан олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн саналд товёог хийж, ил тод байршуулах;

4.13 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн 5.7-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэлд байр, талбай, тоног төхөөрөмжийн түрээс, акталсан эд хогшил, тоног төхөөрөмжийн мэдээллийг ил тод байршуулах;

4.14 Зорилтот түвшинд хүрээгүй буюу аймгийн дунджаас муу үзүүлэлттэй байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

4.15 Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллах.

Тав. Нэгдсэн үнэлгээ

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	87.1	0.2	17.4
2	ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	83.4	0.15	12.5
3	Мэдээллийн ил то байдлыг илтгэх үзүүлэлт	61.9	0.15	9.3
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	58.3	0.3	17.5
5	Хэрэглэгчийн үнэлгээ	86	0.2	17.2
6	Ерөнхий үзүүлэлт			73.9

Эрүүл мэндийн яам
2025 оны 04 дүгээр сар

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн үнэлгээ				
д/д	Үзүүлэлт	2023	2024	
			Хүрсэн түвшин	Зорилтот түвшин
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	92.4	92.6	93.0
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	74.6	97.0	85.1
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан зорилтот 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	23023	26752	23107
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан зорилтот 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	65.8	68.7	66.8
5	Элэгний хорт хавдрын өвчлөлийн эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь	95.9	98.6	
6	Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь	27.5	29.5	
7	В гепатитийн вакцин /24 цаг/	100.0	99.8	100.0
8	СХТ + Геп В +ХиВ-ийн тавт вакцин	99.8	99.6	99.9
9	УГУ-ын 3-т вакцин	99.9	98.8	100.0
10	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь	96.7	96.5	97.7
11	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь	21.3	21.1	
12	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь	82	61	
13	Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлтөд/	0.0	0.0	0.0
14	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	7.9	6.6	6.9
15	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	10.4	7.7	9.4
16	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.9	3.8	3.9
17	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	8.7	6.7	7.7
18	Үр хөндөлтийн түвшин (15-49 насны 1000 эмэгтэйд)	19.4	16.7	
19	1000 жирэмсэнд ногдох үр хөндөлтийн түвшин	423.1	318.8	
20	Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин	2.2	2.5	
21	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0 -74 насны 10 000 хүн амд)	0.2	0.3	
22	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	0.1	0.4	
23	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	0.0	0.0	
24	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	0.0	0.0	
25	Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	0.2	0.4	
26	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	1.2	1.8	
27	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)	1.7	0.9	
28	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	15.8	17.2	14.5
29	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	14.5	15.4	13.5
30	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (10 000 хүн амд)	1.1	0.4	0.7
31	Өсвөр насны 1 000 хүнд ногдох амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин	0.0	0.0	
32	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд)	0.7	0.6	
33	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд)	2.2	1.5	1.7
34	Сүрьеэгийн нас баралтын түвшин (10 000 хүн амд)	0.6	0.5	
35	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь	82.9	77.8	
36	Вируст гепатитын өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)	0.1	0.5	0.0
37	Төрөлхийн тэмбүүгийн тоо	1	0.0	
ДҮН		58.3		